



СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 10 сарын 22 өдөр

Дугаар 154

Сүхбаатар сум


“Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх  
хөтөлбөр” батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.9, Хууль тогтоомжийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.“Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх аймгийн хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, нэгдсэн удирдлагаар хангах хөтөлбөрийн биелэлтийн явцыг 2 жил тутамд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Ш.Оргил/-д даалгасугай.

ДАРГА  Г.БЯМБАА



**“ИРГЭДИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ”  
АЙМГИЙН ХӨТӨЛБӨР**

**Нэг. Хөтөлбөрийн зорилго**

1.1.Хууль, тогтоомжийг олон нийтэд тайлбарлан таниулах, сурталчлах, иргэдийн эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг өргөжүүлэх олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлэх замаар иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлж, хууль зүйн туслалцааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

**Хоёр. Хөтөлбөрийн зорилт**

2.1.Энэхүү хөтөлбөрийн 1.1-д заасан зорилгод хүрэхийн тулд дараахь зорилтыг үе шаттай хэрэгжүүлнэ:

2.1.1.Хууль, тогтоомжийг олон нийтэд тайлбарлан таниулах, сурталчлах ажлыг энгийн ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулах;

2.1.2.Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлэх олон талт ажил, арга хэмжээг зохион байгуулах;

2.1.3.Хууль тогтоомжийн сургалт, сурталчилгаа явуулах хүний нөөцийг бэлтгэх, чадавхижуулах, хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдвэрлэх;

2.1.4.Хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг өргөжүүлэх;

2.1.5.Хууль зүйн клиник сургалтын төв байгуулах;

**Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим**

3.1.Хөтөлбөрт тусгагдсан ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Үндсэн хуульд зааснаас гадна дараахь зарчмыг баримтална:

3.1.1.Хууль заавал хэрэгждэг, хүн бүрт эрх тэгш, алагчлалгүй, шударга үйлчилдэг, итгэл хүлээсэн хүний эрхийн мэдрэмжтэй, шударга ёсны засаглалыг бэхжүүлэх зарчмыг баримтална.

3.1.2. "Иргэдийн с эрх зүйн боловсролыг дээшлүүлэх" хөтөлбөр нь хууль тогтоомж сурталчлах, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хууль зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр гаргасан хууль тогтоомж, дүрэм, журам, хөтөлбөр болон улс, аймаг, орон нутгийн хөгжлийн бодлого, чиглэлтэй уялдсан байна.

3.1.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг төр, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, төрийн албан хаагч, хуульч, өмгөөлөгч, оюутан, иргэд олон нийтийн оролцоо, дэмжлэг, нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан зохион байгуулна.

**Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

4.1."Хууль, тогтоомжийг олон нийтэд тайлбарлан таниулах, сурталчлах ажлыг энгийн ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулах" нэгдүгээр зорилтын хүрээнд дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.1.1.Төр, төсвийн байгууллагуудын хууль тогтоомж сурталчлах ажлыг нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу үр дүнтэйгээр зохион байгуулдаг арга хэлбэрт шилжүүлэх;

4.1.2.Хууль тогтоомжийг олон нийтэд тайлбарлан таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулахдаа эрх зүйн мэдээлэл бэлтгэх, түгээх аргачлалыг баримтлан, цар хүрээний хувьд нийт нутаг дэвсгэрийг хамарч, иргэн бүрт хүрсэн байх нөхцөлийг хангах;

4.1.3.Аймаг, сум, агентлаг, байгууллага бүрийг салбар, чиглэлийн хууль тогтоомжийн цаасан болон цахим сантай болгох;

4.1.4.Хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, хүний эрхийг хамгаалах чиглэлээр уралдаан, тэмцээн, аян гэх мэт олон талт ажлуудыг зохион явуулах;

4.1.5.Хууль, эрх зүйн сэдэвт лекц, ярианы сэдэв, гарын авлага материалыг боловсруулж бэлтгэх ажлыг тогтмолжуулах;

4.1.6.Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас гаргаж буй тогтоол, захирамж, шийдвэрийн эмхтгэлийг жил бүр гаргаж иргэд, олон нийтэд сурталчлах, мэдээлэх ажлыг зохион байгуулах;

4.1.7.Хэвлэл, мэдээллийн болон төрийн бус байгууллагуудтай хууль тогтоомж сурталчлах чиглэлээр гэрээ байгуулж, хамтран ажиллах;

4.1.8.Хууль тогтоомжийг сурталчлах ажилд аймаг, сум, байгууллагын албан ёсны цахим хуудас болон олон нийтийн цахим сүлжээг өргөнөөр ашиглах;

4.1.9.Зорилтот бүлгийн /төлбөрийн чадваргүй болон хөгжлийн бэрхшээлтэй/ иргэдэд зориулсан сурталчилгааны материалыг бэлтгэж, түгээх ажлыг зохион байгуулах;

4.1.10.Хууль, эрх зүйн болон шаардлагатай мэдээлэл хайх, эрэлхийлэх, олж авах эх сурвалжийн талаарх мэдээ мэдээллийг бэлтгэж, түгээх;

**4.2."Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлэх олон талт ажил, арга хэмжээг зохион байгуулах" хоёрдугаар зорилтын хүрээнд дараах ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: Үүнд**

4.2.1.Хууль, эрх зүйн албан бус сургалтыг жил бүр тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу хүртээмжтэй, ойлгомжтой хэлбэрээр зохион байгуулж, сургалтын үйл ажиллагаа нь зорилтот бүлгүүдэд хүрсэн байх нөхцөлийг хангах;

4.2.2 Хууль тогтоомж сурталчлах, зөвлөгөө өгөх "Эрх зүйн хөтөч"-ийг сум, багуудад ажиллуулах асуудлыг судалж шийдвэрлэх;

4.2.3.Олон улсын хандивлагч байгууллагуудаас иргэдэд эрх зүйн албан бус боловсрол олгох чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хөтөлбөр, төслүүд, иргэний нийгмийн байгууллагуудын санал, санаачлагыг дэмжиж үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах;

4.2.4.Иргэд, олон нийтийн хэрэгцээ сонирхлыг харгалзан хууль зүйн мэдлэг олгох, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх сургалтыг ганцаарчилсан болон зорилтот бүлэгт зориулан явуулах;

4.2.5.Хууль, эрх зүйн сургалтын гарын авлага, материалыг боловсруулж бэлтгэх ажлыг тогтмолжуулах;

4.2.6.Иргэд, олон нийтийн хууль, эрх зүйн сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгааг аймаг, сумын хэмжээнд хийх;

4.2.7.Хууль, эрх зүй, хүний эрхийг хангах чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээ бүтээл туурвил хийдэг эрдэмтэн, судлаачдыг дэмжиж хамтран ажиллах;

4.2.8.Эрдэм шинжилгээний болон онол практикийн бага хурал зохион байгуулах;

4.2.9.Сум, багийн төвүүдэд “Цахим эрх зүйн хөтөч” ашиглах боломж нөхцлийг бүрдүүлэх;

**4.3.“Хууль тогтоомжийн сургалт, сурталчилгаа явуулах хүний нөөцийг бэлтгэх, чадавхижуулах, хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдвэрлэх” гуравдугаар зорилтын хүрээнд дараах ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: Үүнд**

4.3.1.Сум, тосгон, агентлагт ажиллаж буй төрийн захиргаа, хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн болон хуулийн зөвлөхийн орон тоог хадгалж, цаашид төр, төсвийн байгууллагуудад уг орон тоог бий болгон нэмэгдүүлэх асуудлыг судалж шийдвэрлүүлэх;

4.3.2.Төрийн албан хаагчдыг сургалтанд хамруулах, мэргэшлийг дээшлүүлэх замаар хууль, эрх зүйн сургалт, сурталчилгаа явуулах сургагч багш нарыг бэлтгэх;

4.3.3.Мэргэжлийн хуульчдын баг, бүлгийг шинээр зохион байгуулж, холбогдох төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;

4.3.4.Эрх зүйн хөтөч /паралегал/-үүдийг бэлтгэх, чадавхижуулах ажлыг зохион байгуулах, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэх;

4.3.5.Хоёр дахь шатны буюу мэргэжлийн хууль зүйн /Про боно/ үйлчилгээ үзүүлж буй хуульчдыг давтан сургалтанд хамруулах, сургах, зохион байгуулахад бодлого зохицуулалтын дэмжлэг үзүүлэх;

4.3.6.Хууль тогтоомжийг тайлбарлан таниулах, сургалт, сурталчилгаа явуулах зардлыг аймаг, сум, байгууллага бүр жилийн бүрийн төсөвтөө тусгаж, зориулалтын дагуу зарцуулах;

4.3.7.Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх санхүүгийн эх үүсвэрийг бий болгох /орон нутгийн төсөвт тусгах, хандив тусламж, төсөл хөтөлбөрт хамрагдах зэргээр/ асуудлыг судлан шийдвэрлүүлэх;

4.3.8.Аймаг, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагыг дээшлүүлж, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

4.3.9.Олон улсын хандивлагч байгууллагуудаас хууль, эрх зүйн сургалт, сурталчилгаа явуулах, хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хөтөлбөр, төслүүдэд хамрагдах;

4.3.10.Иргэний нийгмийн байгууллагуудын санаачлагыг дэмжиж, хамтарч ажиллах;

**4.4.”Хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг өргөжүүлэх” дөрөвдүгээр зорилтын хүрээнд дараах ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: Үүнд**

4.4.1.Анхан шатны хууль зүйн туслалцаа үзүүлэх бүтцийг өргөжүүлж паралегал буюу хуульч биш хуульчаар дамжуулан /сумдад “Эрх зүйн хөтөч” ажиллуулах, цахим эрх зүйн хөтөч ашиглах/ хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах;

4.4.2.Хоёр дахь шатны хууль зүйн туслалцаа буюу “Про боно” үйлчилгээ үзүүлэх ажлыг /хуульчийн нийгэмд тустай ажил буюу үнэ төлбөргүй мэргэжлийн хууль зүйн туслалцаа үзүүлдэг соёл/ хуулийн фирм, хуульч, өмгөөлөгч нартай хамтран зохион байгуулах;

4.4.3. Хүний эрхийг хамгаалах бүлэг ажиллуулах, стратегийн өмгөөлөл үзүүлэх ажлыг төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

4.4.4. Зорилтот бүлгийн болон төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах;

4.4.5. Алтанбулаг, Сайхан, Ерөө, Цагааннуур сумдад Хууль зүйн туслалцааны төв байгуулах асуудлыг судалж, шийдвэрлүүлэх;

4.4.6. Төлбөрийн чадваргүй иргэдийн эрх ашгийг хамгаалан ажиллахад төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж, эрх ашгаа хамгаалах талаар сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах;

4.4.7. Хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээ авах хэрэгцээ, боломжийг тодорхойлох судалгааг аймаг, сумын хэмжээнд хийх;

**4.5. Хууль зүйн клиник сургалтын төв байгуулах тавдугаар зорилтын хүрээнд дараах ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: Үүнд**

4.5.1. Хууль, эрх зүйн чиглэлээр сурч буй төгсөх ангийн оюутнуудыг аймаг, орон нутагтаа практик дадлага эзэмших боломж нөхцлийг хангаж "Хууль зүйн клиник сургалтын төв"-ийг Сүхбаатар, Мандал, Сайхан сумдад байгуулах боломж нөхцөлийг судалж шийдвэрлүүлэх;

4.5.2. Хууль зүйн клиник төвийг шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр, шүүхийн шинжилгээ зэрэг шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудад байгуулах боломж нөхцөл, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, шийдвэрлэх;

4.5.3. Төлбөрийн чадваргүй болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хууль зүйн туслалцаа зөвлөгөөг тогтмол өгөх, эрх зүйн боловсролоо дээшлүүлэх, эрхээ хамгаалах, нэхэмжлэл гаргахад дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;

4.5.4. Сум, орон нутагт хомс байгаа хуульчдын орон тоог нөхөх, хүний нөөцийг бүрдүүлэх, чадавхижуулахад дэмжлэг үзүүлэх;

4.5.5. Хууль зүйн клиник сургалтын төв байгуулах талаар санал санаачлага гаргасан сургалт, эрдэм шинжилгээний байгууллагыг дэмжиж, хамтран ажиллах;

**Тав. Хөтөлбөрийн хугацаа, санхүүжилт, тайлагналт**

**5.1. Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа:**

5.1.1. Хөтөлбөрийг аймгийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэд хэрэгжүүлнэ.

5.1.2. Хөтөлбөрийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

I үе шат: 2017-2020

II үе шат: 2021-2023

**5.2 Хөтөлбөрийн санхүүжилт**

5.2.1. Аймаг, сум, байгууллагын төсөв;

5.2.2. Аж ахуйн нэгж, байгууллага, компаниас нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх болон хууль тогтоомж сурталчлах, сургалт зохион байгуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан дэмжлэг, хөрөнгө оруулалт, хандив, тусламж;

5.2.3. Хууль зүй, дотоод хэргийн яам, олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

### **5.3.Хөтөлбөрийг тайлагнах**

5.3.1.Төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг жил бүр төлөвлөн зохион байгуулж, үр дүнг тооцож, сумын Засаг даргын Тамгын газарт тайлагнах бөгөөд сумын Засаг даргын Тамгын газар нь тайланг нэгтгэн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаа тайлагнана.

5.3.2.Сумын Засаг даргын Тамгын газар сумын хэмжээний тайланг нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлээг хийж аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс болон Хууль, эрх зүйн хэлтэст ирүүлнэ.

5.3.3.Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс нь аймгийн хэмжээнд тайлан, мэдээг нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж аймгийн Засаг даргад жил тутам, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 2 жил тутам тус тус тайлагнана.

### **Зургаа.Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ**

#### **6.1.Хөтөлбөрийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэнэ:**

##### **6.1.1.Нэгдүгээр үе шат буюу 2017-2020 онд:**

6.1.1.1.Эрх зүйн албан бус сургалтын болон хууль зүйн туслалцаа, зөвлөгөө авах хэрэгцээний судалгааг хийж, сургалтын агуулга, арга зүйг тодорхойлон боловсруулж, сургалт, үйлчилгээг зохион байгуулах хүний нөөцийг бэлтгэж, чадавхижуулсан байна.

6.1.1.2.Хууль тогтоомж сурталчлах шинэлэг арга хэлбэрийг нэвтрүүлсэн байна.

6.1.1.3.Эрх зүйн албан бус сургалтын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж цаашдын бодлого чиглэлийг тодорхойлсон байна.

##### **6.1.2.Хоёрдугаар үе шат буюу 2021-2023 онд:**

6.1.2.1.Хууль зүйн туслалцаа үзүүлэх паралегаль, про боно үйлчилгээ нэвтэрсэн байна.

6.1.2.2.Орон нутгийн хэмжээнд эрх зүйн албан бус сургалт болон хууль зүйн туслалцааны ажлыг өргөжүүлж, хууль зүйн клиник сургалтын төвтэй болсон байна.

6.1.2.3.Эрх зүйн албан бус сургалтын хүртээмж, чанар, үр нөлөөг өнөөгийн төвшингөөс эрс дээшлүүлж, орчин үеийн мэдээлэл, харилцаа холбооны сүлжээг ашиглан, мэдээллийн шинэ технологийг сургалтанд нэвтрүүлсэн байна.

#### **6.2 Хяналт-шинжилгээ, үнэлгээ**

6.2.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, иргэд, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй хамтран гүйцэтгэнэ.

#### **Долоо. Хүлээгдэж буй үр дүн**

7.1.Хууль, эрх зүйн сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлын агуулга, арга зүйг зөв тодорхойлж, иргэдийн бодит хэрэгцээнд нийцүүлэн зохион байгуулах чадвар бүхий эрх зүйн сургалт, сурталчилгааны бүтэц болон хүний нөөцтэй болсон байна.

7.2.Эрх зүйн сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлыг зөв оновчтой зохион байгуулснаар иргэдийн хууль, эрх зүйн анхан шатны мэдлэгийн түвшин дээшилсэн байхын зэрэгцээ иргэд нийгмийн харилцаанд ухамсартай, хариуцлагатай оролцох, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үнэт зүйлсийн талаархи зөв төлөвшлийг олгох, хөгжүүлэхэд ахиц гарсан байна.

7.3.Иргэд эрх зүйн харилцаанд ухамсар соёлтойгоор оролцож, хууль тогтоомжийг амьдралдаа хэрэглэх, эрх ашгаа хамгаалах чадвартай болсон байна.

7.4.Гэмт хэрэг, эрх зүйн зөрчлийн гаралт тодорхой хувиар буурахад нөлөөлсөн байна.

7.5.Хууль зүйн клиник сургалтын төвтэй болж, үйл ажиллагаа нь тогтмолжсон байна.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС